

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/157/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit02@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага.....	17
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитын илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БСУГ	Боловсрол Соёл Урлагийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/140
танай _____ -ны № _____ -т
Зөрчилгүй дүгнэлт

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх, үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ



D 2022/2022 он/ALBAN BICHIG
19020452

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>144,119,685.22</u>	<u>155,296,984.85</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	144,119,685.22	155,296,984.85
351	Түүхий эд материал	538,390.00	681,390.00
35130	Эм боох материал	538,390.00	681,390.00
354	Хангамжийн материал	139,691,295.22	149,115,594.85
35410	Бичиг хэргийн материал	59,520.00	510,848.00
35420	Аж ахуйн материал	2,143,740.00	2,884,320.00
35450	Барилгын засварын материал	245,000.00	245,000.00
35460	Хүнсний материал	6,338,696.00	4,827,201.00
35470	Бусад хангамжийн материал	130,904,339.22	140,648,225.85
35600	Мал амьтад	3,890,000.00	5,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,780,622,597.01</u>	<u>1,757,665,740.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,780,622,597.01	1,757,665,740.48
392	Биет хөрөнгө	1,745,933,797.01	1,722,976,940.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,633,764,615.00	1,656,864,615.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,026,718.40)	(80,288,211.97)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,500,000.00	5,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,500,000.00)	(5,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	158,682,339.00	162,015,339.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(115,649,383.74)	(129,159,927.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	138,232,422.80	138,232,422.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(78,816,189.30)	(93,571,282.51)
39214	Бусад үндсэн хөрөнгө	101,087,254.00	117,087,254.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(50,451,543.35)	(61,287,269.07)
	Номын фонд	12,111,001.00	13,084,001.00
393	Биет бус хөрөнгө	34,688,800.00	34,688,800.00
39301	Программ хангамж	1,120,000.00	1,120,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34,688,800.00	34,688,800.00
39304	Хасагдуулга	(1,120,000.00)	(1,120,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,924,742,282.23</u>	<u>1,912,962,725.33</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	803,150.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	803,150.00	-
413	Өглөг	803,150.00	-
4136	Бусад өглөг	803,150.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	803,150.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,923,939,132.23</u>	<u>1,912,962,725.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,923,939,132.23	1,912,962,725.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	549,958,766.20	549,958,766.20
51101	Өмч: - төрийн	549,958,766.20	549,958,766.20
512	Хуримтлагдсан үр дүн	(9,166,035.23)	(20,142,442.13)
51210	Өмнөх үеийн үр дүн	(9,166,035.23)	(9,166,035.23)
51220	Тайлант үеийн үр дүн		(10,976,406.90)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,383,146,401.26	1,383,146,401.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,924,742,282.23</u>	<u>1,912,962,725.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,287,295,883.40	1,223,715,684.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,115,383.40	46,913,886.63
120	Нийтлэг татварын бус орлого	41,115,383.40	46,913,886.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,115,383.40	46,913,886.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,765,250.00	1,610,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,350,133.40	45,303,886.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	166,344,700.00	161,544,198.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,079,835,800.00	1,015,257,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,282,800.00	22,343,698.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,282,800.00	22,343,698.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	126,061,900.00	139,200,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	126,061,900.00	139,200,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,311,993,618.28	1,235,209,591.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,311,993,618.28	1,235,209,591.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,152,603,775.73	1,180,108,355.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	809,704,663.83	812,926,636.15
210101	Үндсэн цалин	567,334,146.83	516,597,665.53
210102	Нэмэгдэл	163,167,679.00	218,150,167.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,250,200.00	21,272,000.00
210104	Урамшуулал	60,952,638.00	56,906,802.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,857,178.62	106,495,733.91
210201	Тэтгэврийн даатгал	68,889,270.72	74,337,321.39
210202	Тэтгэмжийн даатгал	8,927,450.06	8,338,312.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,471,641.59	6,505,978.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,506,255.01	1,573,855.93
210205	Эрүүл мэндийн даатгал	15,062,561.24	15,740,265.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,800,515.00	134,383,893.00
210301	Гэрэл, цахилгаан	7,913,182.00	5,789,813.00
210302	Түлш, халаалт	105,487,333.00	128,594,080.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	5,506,250.00	3,838,270.00
210401	Бичиг хэрэг	400,000.00	725,220.00
210402	Тээвэр, шатахуун	650,000.00	720,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	629,860.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	183,200.00	67,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,473,050.00	1,695,550.00
2105	Нормативт зардал	35,968,485.00	39,193,966.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,000.00	357,000.00
210502	Хоол, хүнс	34,896,835.00	36,571,196.00

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	791,650.00	2,265,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,324,800.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	4,324,800.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	153,000.00	168,000.00
210702	Дотоод албан томилолт	153,000.00	168,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,898,800.00	8,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,898,800.00	8,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,390,083.28	74,101,856.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,429,935.00	3,070,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,959,245.00	4,669,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	72,000,903.28	66,362,856.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,389,842.55	55,101,235.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,844,200.00	44,863,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,361,400.00	29,691,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,430,600.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,852,200.00	13,972,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,545,642.55	10,238,135.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,545,642.55	10,238,135.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(24,697,734.88)	(11,493,906.90)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		1,370,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		1,370,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,906,426.00	852,500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,120,000.00	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,786,426.00	852,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,906,426.00)	517,500.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(28,604,160.88)	(10,976,406.90)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	19,438,125.65	1,952,543,293.11
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(28,604,160.88)	(28,604,160.88)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	(9,166,035.23)	1,923,939,132.23
D01	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	(9,166,035.23)	1,923,939,132.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	(9,166,035.23)	1,923,939,132.23
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,976,406.90)	(10,976,406.90)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	(20,142,442.13)	1,912,962,725.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

S			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,246,180,500.00</u>	<u>1,176,801,798.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,246,180,500.00	1,176,801,798.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,079,835,800.00	1,015,257,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,282,800.00	22,343,698.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,282,800.00	22,343,698.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	126,061,900.00	139,200,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	126,061,900.00	139,200,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,246,180,500.00</u>	<u>1,172,835,798.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,246,180,500.00	1,172,835,798.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,083,648,302.45	1,117,734,562.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	809,704,663.83	812,926,636.15
210101	Үндсэн цалин	546,122,444.91	516,597,665.53
210102	Нэмэгдэл	210,973,427.92	248,907,889.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,184,800.00	9,058,000.00
210104	Урамшуулал	37,423,991.00	38,363,081.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,857,178.62	106,495,733.91
210201	Тэтгэврийн даатгал	68,939,669.88	74,337,321.39
210202	Тэтгэмжийн даатгал	8,851,849.85	8,338,312.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,478,361.20	6,505,978.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,507,935.24	1,573,855.93
210205	Эрүүл мэндийн даатгал	15,079,362.45	15,740,265.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,800,515.00	134,383,893.00
210301	Гэрэл, цахилгаан	7,913,182.00	5,789,813.00
210302	Түлш, халаалт	105,487,333.00	128,594,080.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	6,137,165.00	4,699,598.00
210401	Бичиг хэрэг	400,000.00	1,176,548.00
210402	Тээвэр, шатахуун	650,000.00	720,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	679,860.00
210404	Ном, хэвлэл	483,765.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	183,200.00	67,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,620,200.00	2,055,550.00
2105	Нормативт зардал	36,028,345.00	38,559,701.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,000.00	500,000.00
210502	Хоол, хүнс	33,948,345.00	35,059,701.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,324,800.00	1,000,000.00

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	4,324,800.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	153,000.00	168,000.00
210702	Дотоод албан томилолт	153,000.00	168,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,541,435.00	8,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,541,435.00	8,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,101,200.00	11,501,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,700.00	1,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,912,500.00	9,801,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,532,197.55	55,101,235.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,844,200.00	44,863,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,361,400.00	29,691,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,430,600.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,852,200.00	13,972,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,687,997.55	10,238,135.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,687,997.55	10,238,135.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>3,966,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		3,966,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		3,966,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		3,966,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	3,333,000.00
223001	Бусад хөрөнгө	-	633,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(3,966,000.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,154,458,100.00	1,144,239,964.06	10,218,135.94	99.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,154,458,100.00	1,144,239,964.06	10,218,135.94	99.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,122,925,700.00	1,113,348,964.06	9,576,735.94	99.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	812,926,700.00	812,926,636.15	63.85	100.00
210101	Үндсэн цалин	517,479,300.00	516,597,665.53	881,634.47	99.83
210102	Нэмэгдэл	218,299,000.00	248,907,889.30	(30,608,889.30)	114.02

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,156,000.00	9,058,000.00	15,098,000.00	37.50
210104	Урамшуулал	52,992,400.00	38,363,081.32	14,629,318.68	72.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,745,100.00	106,495,733.91	3,249,366.09	97.04
210201	Тэтгэврийн даатгал	77,228,000.00	74,337,321.39	2,890,678.61	96.26
210202	Тэтгэмжийн даатгал	8,129,300.00	8,338,312.18	(209,012.18)	102.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,503,400.00	6,505,978.98	(2,578.98)	100.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,625,900.00	1,573,855.93	52,044.07	96.80
210205	Эрүүл мэндийн даатгал	16,258,500.00	15,740,265.43	518,234.57	96.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,200,500.00	134,383,893.00	3,816,607.00	97.24
210301	Гэрэл, цахилгаан	11,523,200.00	5,789,813.00	5,733,387.00	50.24
210302	Түлш, халаалт	121,950,100.00	128,594,080.00	(6,643,980.00)	105.45
210303	Цэвэр, бохир ус	4,727,200.00		4,727,200.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	4,961,000.00	4,961,000.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	450,000.00	804,950.00	(354,950.00)	178.88
210402	Тээвэр, шатахуун	650,000.00	720,140.00	(70,140.00)	110.79
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.00	679,860.00	70,140.00	90.65
210404	Ном, хэвлэл	485,000.00	633,000.00	(148,000.00)	130.52
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	67,500.00	112,500.00	37.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,446,000.00	2,055,550.00	390,450.00	84.04
2105	Нормативт зардал	41,015,400.00	38,559,701.00	2,455,699.00	94.01
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	500,000.00	-	100.00
210502	Хоол, хүнс	37,515,400.00	35,059,701.00	2,455,699.00	93.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	223,000.00	168,000.00	55,000.00	75.34
210702	Дотоод албан томилолт	223,000.00	168,000.00	55,000.00	75.34
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,000,000.00	8,000,000.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00	8,000,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,854,000.00	6,854,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,700,000.00	1,700,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,154,000.00	5,154,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,532,400.00	30,891,000.00	641,400.00	97.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,532,400.00	30,891,000.00	641,400.00	97.97

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,332,400.00	29,691,000.00	641,400.00	97.89
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,154,458,100.00	1,144,239,964.06	10,218,135.94	99.11
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,015,257,600.00	1,008,856,071.06	6,401,528.94	99.37
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,015,257,600.00	1,008,856,071.06	6,401,528.94	99.37
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	139,200,500.00	135,383,893.00	3,816,607.00	97.26
132001	Орон нутгийн төсвөөс	139,200,500.00	135,383,893.00	3,816,607.00	97.26

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Тайлант оны	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		22,323,698.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		22,323,698.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,351,598.00
2104	Хангамж, бараа материалын зардал		371,598.00
210401	Бичиг хэрэг		371,598.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		7,980,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,980,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,972,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		13,972,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		13,972,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		22,323,698.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		22,323,698.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		22,323,698.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовн туслах Э.Алтангэрэл, аудиторовн туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Жишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 26,239.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,679.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 24,704.2 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 18,528.1 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 1,535.7 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

төгрөг/	/мянган		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	144,119.7	155,296.9	11,177.2
Үндсэн хөрөнгө	1,780,622.6	1,757,665.7	(22,965.9)
Нийт хөрөнгө	1,924,742.3	1,912,962.7	(11,779.6)
Өр төлбөр	803.2	-	(803.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,923,939.1	1,912,962.7	(10,976.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,924,742.3	1,912,962.7	(11,779.6)

Бараа материал дансны үлдэгдэл 155,296.9 мянган төгрөг болж 11,177.2 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь 82,545.9 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авсан, 6,863.9 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжин ирснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,757,665.7 мянган төгрөг болж, 22,965.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс Заамар нутгийн хөгжлийг дэмжих сангаас хандивласан бөхийн дэвжээний 16,000.0 мянган төгрөгөөр, дотуур байрны фасад засварын ажлыг хийж гүйцэтгэснийг барилга байгууламжийн дансанд бүртгэсэн 23,100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ. Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардал 66,362.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,223,715.7 мянган төгрөг болж өмнөх оноос 63,580.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 17,939.1 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,235,209.6 мянган төгрөг болж өмнөх оноос 76,784.0 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,195,608.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,195,608.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 41,150.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,154,458.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 32 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,154,458.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,015,257.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 139,200.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,015,257.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 139,200.5 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 1,154,458.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,144,239.9 мянган төгрөгийг зарцуулж, 10,218.1 мянган төгрөгийн улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 22,343.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 22,323.7 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 20.0 мянган төгрөгийг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө данс Заамар нутгийн хөгжлийг дэмжих сангаас хандивласан бөхийн дэвжээний 16,000.0 мянган төгрөгөөр, дотуур байрны фасад засварын ажлыг хийж

гүйцэтгэснийг барилга байгууламжийн дансанд бүртгэсэн 23,100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнийг бүртгэж тайлагнасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1,521,976.9 мянган төгрөгийн 52 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 1,197,458.4 мянган төгрөгийн 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, хөрөнгө бэлтгээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, хоолны материалын үлдэгдэлтэй холбоотой 1 акт, И баримттай холбоотой албан шаардлага тус тус 100.0 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	6,338.7	1	6,338.7	-	-	100.0
Албан шаардлага	1	48,031.6	1	48,031.6	-	-	100.0
Зөвлөмж	1	-	1	-	-	-	100.0
Нийт дүн	3	54,370.3	3	54,370.3	-	-	100.0

/мянган төгрөг/

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,210,849.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,966.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 8,449.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 975.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,197,458.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын зардлын дүнд худалдан авсан 3,966.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлагнаагүй, үндсэн үйл ажиллагааны зардалд тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 хавсралтын 6.9-д “Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарлага хэсэгт „, үндсэн хөрөнгө худалдан авах, олж бэлтгэхэд болон капиталжих их засварт зарцуулсан мөнгөн зардлыг харуулна”, санхүүгийн тайлангийн аудитын “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

1. Цалинг буруу тооцож олгосонтой холбоотой нийт 3,622.3 мянган төгрөгийн алдаа зөрчилтэй байна. Үүнд:

1.1 Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 4 ажилтны цалингаас ХХОАТ чөлөөлөлгүй тооцоноос 3,573.0 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

1.2 Хөдөлмөрийн чадвар алдсаны актын хугацаа дууссан 1 ажилтны 10-12 дугаар сарын цалингаас НДШ-ийг 44.8 мянган төгрөгөөр дутуу, ХХОАТ-ыг 4.5 мянган төгрөгөөр илүү суутгасан.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1-д "Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", 7.1.6-д "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 4,827.2 мянган төгрөгийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", "УСНББОУС 12 бараа материалд тавигдах шаардлага, санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Байгууллага нь нийт 6 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 975.3 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.8-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 545 ширхэг 160,100.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", санхүүгийн тайлангийн аудитын "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1,521,976.9 мянган төгрөгийн 52 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 1,197,458.4 мянган төгрөгийн 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Мөнгөн гүйлгээний хөрөнгө оруулалтын дүнд худалдан авсан хөрөнгийг бүртгээгүй	1	3,966.0	1	3,966.0						
2	Хүүхдийн хоолны материалын хэмнэгдсэн төсвийн үлдэгдлийг нэгдсэн дансанд төвлөрүүлээгүй	1	4,827.2			1	4,827.2				
3	Цалинг буруу тооцоолж олгосон	2	3,622.3			2	3,622.3				
4	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	975.3					1	975.3		
5	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		6	13,390.8	1	3,966.0	3	8,449.5	1	975.3	1	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	1,197,458.4							1	1,197,458.4
Дүн		1	1,197,458.4	-	-	-	-	-	-	1	1,197,458.4
Нийт дүн		7	1,210,849.2	1	3,966.0	3	8,449.5	1	975.3	2	1,197,458.4